



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 13 өдөр

Дугаар Д/462

Хэрлэн сум


Тогооч Б.Алтантотьд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Алсын хараа” бодлогын баримт бичгийн хүрээнд Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдах “Чингис хааны цом” олон улсын А зэрэглэлийн тогооч нарын тэмцээнд Ази хоолны төрөлд оролцох тогооч Б.Алтантотийн тэмцээний зардалд 1,000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ